



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 070

Улаанбаатар хот

Нийслэлийн оны шилдэг багш,  
дасгалжуулагч, тамирчин, арга  
зүйч шалгаруулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 10 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч шалгаруулах болзлын дагуу дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодоос шалгаруулан ирүүлсэн хүмүүсийн материал, ажлын үзүүлэлт, үр дүнг үнэлж дүгнэн Нийслэлийн 2016 оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч нарыг сонгон шалгаруулсугай.

2. Нийслэлийн 2016 оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчээр шалгарсан хүмүүсийг шагнах шагналын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд шаардагдах 3.400.000 /гурван сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500138

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын  
хорооны даргын 2016 оны ...*11*...*дунд*...  
сарын *07* ны өдрийн *07* дугаар тушаалын хавсралт



Нийслэлийн оны шилдэг багш,  
дасгалжуулагч, тамирчин, арга  
зүйч шалгаруулах төсөв

| №           | Зардлын нэр  | Зардлын хэмжээ /төг/ | Нийт зардал /төг/ |
|-------------|--|----------------------|-------------------|
| 1.          | Тэргүүний багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчийн шагнал | 5x200.000            | 1.000.000         |
| 2.          | Цом, өргөмжлөл   | 300.000              | 300.000           |
| 3.          | Анонс, урилга  | 100.000              | 100.000           |
| 4           | Заал талбайн түрээс /үзель/ хөтлөгч                          | 2000.000             | 2000.000          |
| <b>ДҮН:</b> |  | <b>3.400.000</b>     | <b>3.400.000</b>  |

Боловсруулсан  
Хянасан

А.Болдмаа  
О.Эрдэнэцэцэг